

ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ОНЦЛОГ


Д.Сумъяацэрэн

ХСИС-ийн Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнгийн, Цагдаа судлалын
төвийн эрдэм шинжилгээний ажилтан, докторант, цагдаагийн ахлах дэслэгч.

1.Холбооны бүгд найрамдах Герман улс

Герман улс нь төрийн байгууламжийн хувьд холбооны улс бөгөөд Үндсэн хуулийн дагуу 16 муж бүр өөрийн нутаг дэвсгэрт дэг журам сахиулах, нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлдэг тул үйл ажиллагааны түвшингээр зааглан авч үзэв. Холбооны улсын түвшинд Холбооны цагдаагийн газар, Холбооны эрүүгийн цагдаагийн газар нь Дотоод хэргийн яамны харьяанд явуулна.

Холбооны цагдаагийн газар нь улсын хилийн аюулгүй байдал, үндэстэн дамнасан болон зохион байгуулалттай гэмт хэрэг, хар тамхи худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ Холбооны ерөнхийлөгчийн ордон, яамд, Үндсэн хуулийн шүүх, ХБНГУ-ын гадаад улс дахь элчин сайдын яамдын харуул хамгаалалтыг хэрэгжүүлнэ.



Холбооны цагдаагийн газрын оффис

Муж (state) бүрийн цагдаагийн байгууллага нь мужийн Дотоод хэргийн яамны харьяанд ажилладаг бөгөөд бүтэц, зохион байгуулалтын хувьд өөр боловч дийлэнх тохиолдолд

Мужийн цагдаагийн газрууд нь дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- Эргүүл хамгаалалт
- Мөрдөх алба – мужийн дотоод хэргийн сайдын харьяанд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийг мөрдөх, хоёр буюу түүнээс дээш орон нутгийн цагдаагийн байгууллага оролцсон мөрдөх ажиллагаанд зохицуулалт хийх чиг үүрэгтэй. Мөрдөх алба нь дэргэдээ терроризмтой тэмцэх, хүн барьцаалах гэмт хэрэгтэй тэмцэх болон гүйцэтгэх ажиллагааны нэгжүүдтэй
- Шуурхай бэлэн байдлын алба /Ready Reaction Force/ - гадаадын төрийн өндөр дээд хэмжээний айлчлал, олон нийтийг хамарсан жагсаал, бослого, үймээн самуун, томоохон спортын арга хэмжээ, олон улсын хурал, цуглаан, байгалийн гамшигт үзэгдэл тохиолдоход бусад салбар нэгжүүдэд ар талын дэмжлэг үзүүлэх болон нэмэлт хүч болох үндсэн чиг үүрэгтэй.

- Авто замын цагдаа–Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зохицуулах, зам тээврийн ослын үед шуурхай хүрч очих, тээврийн хэрэгсэлд аюулгүй байдлын үзлэг нэгжлэг хийх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүрэгтэй.

- Усан замын цагдаа–Усан замын тээврийн хөдөлгөөнийг зохицуулалтийг хийх, усан замаар аюултай ачаа барааг тээвэрлэлтийг хянах.

- Агаарын дэмжлэг үзүүлэх алба /Police Air Support/ - замын хөдөлгөөний ажиглалт хийх, орон нутгийн цагдаагийн алба хаагчдад нэмэлт хүч болох

2.Франц улсын үндэсний цагдаагийн газар /[Police Nationale](#)/

Үндэсний цагдаагийн байгууллагын үндсэн үүрэг нь хүн ам ихтэй, төвлөрсөн хот, хот орчмын бүсийг хариуцах бөгөөд Дотоод хэргийн яамны харьяанд ажиллана. Багцаалбал 150,000 алба хаагчидтай. Үндэсний цагдаагийн газар нь дараахь нэгжүүдэд хуваагдана. Үүнд:

- Захиргаа удирдлагын газар (Directorate of Administration of the National Police)
- Материал хангамж, нөөцийн газар (Directorate of Ressources and Competences of the National Police; DRCPN)
- Үндэсний цагдаагийн газрын сургалтын төв (Directorate of Training of the National Police; DFPN)
- Шүүхийн цагдаагийн газар (Central Directorate of Judicial Police; DCPJ)
- Нийтийн аюулгүй байдлын газар (Central Directorate of Public Security; DCSP) – эргүүл хамгаалалт, хэв журам сахиулах чиг үүрэгтэй бөгөөд нийт алба хаагчдын 80 гаруй хувь
- Хилийн цагдаагийн төв байгууллага (Central Directorate of Border Police; DCPAF),
- Мөрдөн шалгах ерөнхий газар (General Inspectorate of the National Police; IPGN)
- Бүгд найрамдах байгууллын аюулгүй байдлыг сахиулах газар (Central Directorate of the Republican Security Companies; DCCRS) – жагсаал цуглаан, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал
- Олон улсын цагдаагийн байгууллагын техникийн хамтын ажиллагааны хэлтэс (Technical International Police Co-operation Service; SCTIP)
- Тусгай хамгаалалтын газар (Important Persons Protection Service; SPHP)
- Терроризмтой тэмцэх ажлыг зохицуулах нэгж (Counterterrorism Struggle Coordination Unit)

Үндэсний джендарм /[Gendarmerie Nationale](#)/

Gendarmerie нь 5000 – 16000 хүн амтай жижиг тосгон, хөдөө орон нутгийн засаг захиргааны нэгжүүдийг хариуцах бөгөөд Батлан хамгаалах яам /Ministry of Defense/-ы харьяаны агентлаг боловч үйл ажиллагааны удирдлага, хяналт нь Дотоод хэргийн яаманд шууд харьяалагдана. Үндэсний Джендарм нь дотроо хоёр үндсэн бүтцээр үйл ажиллагаа явуулна.

Орон нутагт тархан байрласан нэгжүүд нь шүүхийн /мөрдөн шалгах/ болон цагдаагийн чиг үүргийг хэрэгжүүлнэ /авто замын эргүүл, уул, ой модны эргүүл гэх мэт/

Хөдөлгөөнт джендарм нь мөрдөн шалгах ажиллагаа явуулахгүй бөгөөд тусгай үүрэг даалгавар гүйцэтгэх, эсхүл бусад цагдаагийн нэгжүүдэд нэмэлт хүч болох чиг үүрэгтэй.

Үндэсний Жендарм нь цэрэг, батлан хамгаалахын чиг үүрэгтэй холбоотой далай, нисэх буудал, төрийн /нийтийн/ томоохон албан байгууллагын барилгын аюулгүй байдлыг хариуцдаг байна.


Хөдөө, орон нутаг, тосгон суурин зэрэг засаг захиргааны доод нэгжүүдийн цагдаагийн алба хаагч нь эрүүгийн хэрэг, зөрчлийг хянан шалгах эрхгүй бөгөөд гэмт хэрэг, зөрчлийн талаар эрх бүхий этгээдэд мэдээлж байх үүрэгтэй.

Францын гааль, шууд бус татварын газар /The Directorate-General of Customs and Indirect Taxes/

Төсөв, санхүү, иргэний албаны яамны харьяаны хууль сахиулах байгууллага бөгөөд шууд бус татвар ногдуулах, мөнгө угаах, бэлэн мөнгө хилээр хууль бусаар нэвтрүүлэх, хуурамч (counterfeit of money) мөнгөн тэмдэгт үйлдвэрлэхээс урьдчилан сэргийлэх, тэдгээр гэмт хэргийг илрүүлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг.

3.Польш

THE ORGANIZATION SCHEME OF NATIONAL POLICE HQs



- Эрүүгийн цагдаа (*Policja Kryminalna*) –хүч хэрэглэсэн болон ноцтой гэмт хэрэг мөрдөн шалгах, урьдчилан сэргийлэх
- Эрүүгийн цагдаагийн газар нь дэргэдээ тусгай албадтай байж болно.
- Эрүүгийн цагдаагийн газрын нэгж бүр хэргийн газрын үзлэг хийх албатай байна.
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх алба (*Policja Prewencyjna*) –хууль хэрэгжүүлэх ерөнхий чиг үүргийг хэрэгжүүлж эргүүл хамгаалалтыг хариуцна. (Терроризмтой тэмцэх,)
- Замын цагдаа (*Policja Ruchu Drogowego*)
- Logistical Support Police (*Policja Wspomagajaca*) - provision of logistical support and technical skills
- Цагдаагийн агаарын тусламжийн алба (*Sluzba Lotnictwa Policji*)
- Мөрдөн шалгах алба (*Policja Śledcza*) –эдрээ төвөгтэй гэмт хэргийг шалгаж
- Шүүхийн цагдаа (*Policja Sadowa*) - protection of шүүх, прокурорын газар, процессийн ажиллагааны оролцогчдийг хамгаалах, шүүх хуралдааны дэг журам сахиулах
- Усан замын цагдаа (*Policja Wodna*) –Усан замын эргүүл, хамгаалалт

Польш улсын цагдаагийн байгууллагын шинэчлэл /1999 он/

Дэлхийн хоёрдугаар дайны дараа Польшийн цагдаагийн алба нь цагдаагийн байгууллагаас илүүтэй *Milicja* буюу коммунист байгууллагын бэлгэ тэмдэг болсон цэрэгжсэн байв. Улс төрийн тэрслүү үзэлтнүүдийн үйл ажиллагааг хориглох, таслан зогсоох, баривчлах томоохон хүчин байв. *Milicja* нь коммунист намын шууд удирдлага дор социалист нийгмийн дэг журмыг сахиулах үндсэн чиг үүрэгтэй үйл ажиллагаа явуулдаг байжээ.

1990-1999 оны хооронд цагдаагийн байгууллагыг нэгдсэн төвлөрсөн удирдлагатай, эсхүл орон нутгийн засаг захиргаанд шилжүүлэх зэргээр өөрчлөлт тасралтгүй явагдаж байв. 1996 онд 30 гаруй улс төрийн намууд нэгдэж 1997 оны парламентийн сонгуульд ялалт байгуулсан нь цагдаагийн байгууллагын бүтцийн томоохон өөрчлөлтийн эхлэл байв.


Улмаар мөн онд байгуулагдсан Засгийн газар улсын хэмжээнд төрийн төвлөрсөн удирдлагыг багасгах ажлыг эхлүүлсний нэгэнд цагдаагийн байгууллагын шинэчлэл багтаж байв. Засаг захиргааны нэгжүүдийг шинээр зохион байгуулж 1 саяас 5,1 сая хүртэлх хүн амтай 16 засаг захиргааны үндсэн нэгжийг байгуулав.

Цагдаагийн байгууллагыг шинэчилсэн засаг захиргааны зохион байгуулалтын дагуу шинээр зохион байгуулж Британи-Данийн тогтолцоотой нилээн ойртуулсан тогтолцоог нэвтрүүлжээ. Уг өөрчлөлтийн дагуу мөрдөх алба цагдаагийн байгууллагын төвлөрсөн удирдлагын дор ажиллажнэгдсэн төсвөөс санхүүжиж, харин нийт цагдаагийн алба хаагчдийн дийлэнхийг багтаасан хэв журам сахиулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зэрэг чиг үүрэг бүхий “шинэ” бүтцийг аймаг /province/, дүүрэг, тосгон сууринд бий болгожээ.

Үндэсний цагдаагийн газрын дарга, аймгийн Засаг дарга нарыг Засгийн газраас томилдог тул аймгийн цагдаагийн газрын түвшинд төв засгийн газрын нөлөөлөл байх бололцоотой бол түүнээс доош засаг захиргааны нэгжүүдэд засаг дарга нарыг орон нутгаас сонгодог учир хөндлөнгийн нөлөөлөл орох бололцоогүй юм.



5. Финлянд улс



Финландын цагдаа нь бүс нутгийн 24 хэлтэс, 3 үндсэн агентлагт хуваагддаг. Нэгдүгээрт гэмт хэрэг мөрдөн шалгах, илрүүлэх, урьдчилан сэргийлэх чиг үүрэгтэй Үндэсний мөрдөн шалгах товчоо, Хоёрдугаарт Финланд улсын аюулгүй байдал, тагнуулын газар, Гуравдугаарт Үндэсний замын цагдаа гэсэн агентлагтай.

- Үндэсний мөрдөн шалгах товчоо нь гэмт хэргийн гол мөрдөн шалгах ажиллагааг явуулах бөгөөд хурууны хээ авах гэх мэт гэмт хэргийг илрүүлэх тусгайлсан мөрдлөг явуулдаг.

- Финландын аюулгүй байдал, тагнуулын газар нь үндэсний аюулгүй байдлын эсргэ гэмт хэрэгтэй холбоотой гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх мөрдөн шалгах чиг үүрэгтэй байгууллага юм.

- Үндэсний замын цагдаа нь замын хөдөлгөөний аюулгүй байдал, хууль бус бараа, хар тамхи мансууруулах бодис, хууль бус ан агнуур хийх гэмт хэргийг мөрдөн шалгах чиг үүрэгтэй. Финландын цагдаагийн газарт Цагдаагийн коллеж, цагдаагийн технологийн төв харьяалагдана.

Финландын цагдаагийн газар нь засгийн газрын Дотоод хэргийн яаманд шууд харьяалагдана.

6.Япон улсын цагдаагийн байгууллага

1951 онд Японы парламент нь хотын иргэдэд төвлөрлийг сааруулах зорилтын хүрээнд байгуулагдсан орон нутгийн цагдаагийн газрыг татан буулгах эсэх талаар референдум явуулах эрхийг олгосон хууль баталжээ. Уг хууль батлагдсанаас 6 сарын дараа гэхэд 1028 хотоос 1024 хотын иргэд орон нутгийн цагдаагийн байгууллагыг татан буулгаж үндэсний цагдаагийн байгууллагын бүрэлдэхүүнд шилжүүлэх санал өгсөн байна.

Энэхүү өөрчлөлтийн дараа АНУ цагдаагийн байгууллагыг ардчилсан, төвлөрлийг сааруулах талаарх удаа дараагийн “зөвлөсний” дагуу 1954 онд дахин шинэчилсэн байна. Уг шинэчлэлийн хүрээнд үндэсний цагдаагийн газрыг засаг захиргааны нэгжийн дагуу задалсан байна. нэгжүүдийн удирдлагыг холимог шинжээр зохион байгуулсан байна.

Энэхүү “холимог” шинжтэй удирдлага нь Японы Дотоод хэргийн сайд, засаг захиргааны нэгж, орон нутгийн иргэдийн төлөөллөөс бүрдэх бөгөөд иргэдийн төлөөлөл цагдаагийн байгууллагыг удирдахад шууд оролцохоос илүүтэйгээр “зөвлөх” шинжтэй байна. Дээр дурдсанаас үзэхэд Японы цагдаагийн байгууллагын удирдлагын тогтолцоо нь төвлөрсөн бөгөөд жижиг хэмжээний төвлөрсөн бус тогтолцооны шинжийг агуулж байна.

7.Шинэ Зеланд

Шинэ Зеландын цагдаагийн газар нь гэмт хэргийг мөрдөн шалгах, нийгмийн аюулгүй байдлыг хамгаалах, нийгмийн хэв журмын хангах, Эрүүгийн хуулийг хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэгтэй. Мөн авто зам, галт зэвсгийн тусгай зөвшөөрөл олгох, бүртгэх асуудлыг хариуцна.Шинэ зеландын цагдаа нь Хууль зүйн яамын үндсэн 5 секторын нэг юм.

Хэдийгээр цагдаагийн газрыг комиссар тэргүүлэх боловч эрх мэдэл хэт төвлөрхөөс сэргийлж газар зүйн байрлалаар нь ялгаж 12 дүүрэгт хуваасан. Комиссар нь хүний нөөц, удирдлага болон үйл ажиллагаа хариуцсан 2 орлогчтой байна. 5 ахлах ажилтаныг туслах комиссараар томилж дараах нэгжүүдийг удирдуулна.

Үндэсний гэмт хэргийг мөрдөн шалгах бүлэг, Зохион байгуулалттай болон эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх бүлэг, олон улсын алба, номхон далайн арлуудыг хариуцсан хэрэг эрхлэх газруудыг тус тус хариуцна.

Мөрдөн шалгах болон Олон улсын бүлгийг хариуцсан туслах комиссар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах, онц хүнд хүнд болон хил дамнасан гэмт хэргийг илрүүлэх, цагдаагийн олон улсын хамтын ажиллагааг дэмжих чиг үүргийг хэрэгжүүлнэ. Дараагийн туслах комиссар нь цагдаагийн байгууллагын олон нийт, насан хүрээгүй хүмүүстэй харилцах, харилцаа холбооны төв, үйл ажиллагааны бүлэг, замын цагдаагийн үйл ажиллагааг тус тус хариуцан ажилдаг.

Үлдсэн 3 туслах комиссар нь газар зүйн бүсчлэлээр хойд бүсийг дотор нь өмнө, хойно гэж бүсчлэн 2 нь, өмнөд бүсийг 1 нь гэсэн хувиарлалтаар 3 тойрогт хариуцан ажилдаг байна. ингэхдээ бүсчилсэн тойрог нь дотроо 3-5 дүүрэгт хуваагддаг.